



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

Хариуцлагын даатгал таныг хамгаална



**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН
АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН
ГАРЫН АВЛАГА**



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

Хариуцлагын даатгалыг хамтдаа хөгжүүлье



АВТО ДОРЦОВ

ЖОЛООЧИЙН
УХААЛАГ
ТУСЛАХ



SMART CAR

www.smartcar.mn

Жолооч жолоочийн хариуцлагын даатгалын

- * Гэрээний хугацаагаа шалгах,
- * Даатгалын хураамжаа тооцоолох
- * Замын ачаалал,
- * Авто засвар
- * Шатахуун түгээх газрын хаяг зэрэг тээврийн хэрэгсэлтэй холбогдох бүхий л мэдээллийг авах боломжтой юм.

Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн

- * Албан татвар
- * Агаарын бохирдлын төлбөр
- * Зам ашиглалтын төлбөр
- * Техникийн хяналтын үзлэг оношилгоо
- * Даатгалын мэдээ
- * Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл авах боломжтой.

Хариуцлагын даатгал таныг хамгаална

ХАЙХ ҮГ:
dortsov | daatgal



Available on the
App Store



ХАЙХ ҮГ:
dortsov | daatgal



ANDROID APP ON
Google play

АВТОМАШИНЫ БҮХ МЭДЭЭЛЛИЙГ НЭГ ДОРООС



AutoDortsovApp



@AutoDortsovApp



98117500
99046010

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН
АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН
ГАРЫН АВЛАГА**

2015 ОН

ГАРЧИГ

1. Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилт 3
2. Жолоочийн даатгалын тухай хуулийн нэр томъёоны тодорхойлолт 3-4
3. Жолоочийн даатгалын үндсэн зарчим 4
4. Жолоочийн даатгалд хэн даатгуулах вэ? 4
5. Жолоочийн даатгалын гэрээ, гэрээний хугацаа 5
6. Жолоочийн даатгалын баталгаа 5
7. Жолоочийн даатгалын үнэлгээ ба суурь хураамж 6
8. Даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр 6-8
9. Жолоочийн даатгалын тохиолдолд үл хамаарах хохирол 8
10. Жолоочийн хүлээх үүрэг 9
11. Хохирогчийн хүлээх үүрэг 9
12. Даатгуулагч Та даатгалын тохиолдол гаргасан бол хэнд хандах вэ? 10
13. Дараах тохиолдолд хаана хандах вэ? 11-12
14. Даатгалын тохиолдол гаргасан буруутай этгээдийн бүрдүүлэх материал 12
15. Хохирогчийн бүрдүүлэх материал 12-13
16. Жолоочийн даатгалын сангаас ямар тохиолдолд нөхөн төлбөр олгох вэ? 14
17. Хохирогчид олгох нөхөн төлбөр 14-15
18. Нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх үндэслэл 15-16
19. Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагаас 16-17
20. Даатгуулагчийн анхаарах зүйлс 17

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗОРИЛТ



- Жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах;
- Зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- Хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

“Даатгагч” гэж даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулж, уг гэрээнд заасан нөхцөл, хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

“Даатгуулагч” гэж даатгагчтай гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг;

“Жолоочийн даатгалын тохиолдол” гэж жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, хариуцлага хүлээх тохиолдлыг;

“Жолоочийн даатгалын нөхөн төлбөр” гэж жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө болон даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг;

“Жолоочийн даатгалын сан” гэж жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан түүнчлэн даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан болон

даатгагч нь дампуурсан зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хэд хэдэн даатгагч хамтарч энэ хуульд заасны дагуу байгуулсан санг;

”Шуурхай алба” гэж жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг ажиллуулах, даатгалын тохиолдлын газар дээр шуурхай очиж үзлэг хийх, тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай олгох боломжийг бүрдүүлж ажиллана;

“Хохирогч” гэж даатгалын тохиолдлын улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учирсан этгээд, эсхүл даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд гэм хор учруулсны төлбөрийг шаардах эрх бүхий этгээдийг.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ



- Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах;
- Хохирогчид нөхөн төлбөр олгох;
- Жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх;
- Зам, тээврийн ослын улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ХЭН ДААТГУУЛАХ ВЭ?



- Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр
- Мэргэшсэн жолооч болон С, D ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох



жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамаараад заавал даатгуулна.

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- Жолооч нь замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилгоор энэ хуульд заасан нөхцлийн дагуу даатгагчтай даатгалын гэрээ байгуулна.
- Даатгуулагч нь даатгагчаа сайн дураараа чөлөөтэй сонгох эрхтэй.
- Даатгуулагч мэдүүлгийн маягт¹ бөглөж, гэрээг бичгээр байгуулна.
- Даатгалын гэрээ нэг жил хүртэл хугацаанд хүчинтэй байх бөгөөд даатгуулагчаас даатгалын хураамж төлснөөр хүчин төгөлдөр болно.




ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГАА

Даатгагч, даатгуулагч нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээнд гарын үсэг зурж, жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгүүлэн 14 оронтой дугаар авна. Тухайн гэрээний 14 оронтой дугаар нь Жолоочийн даатгалын баталгаа болох бөгөөд Та гэрээг заавал биедээ болон тээврийн хэрэгсэлдээ авч явах үүрэгтэй.

Эрх бүхий этгээд нь цахимаар болон шалгах төхөөрөмж ашиглан даатгуулагчийн даатгалын гэрээний хүчинтэй хугацаа, жолоочийн даатгалын баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас шалгана.

¹ - Мэдүүлгийн маягыг үнэн зөв бөглөх нь даатгуулагчийн хураамж бодитой гарах үндэслэл болно.



ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ БА СУУРЬ ХУРААМЖ



ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР

Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцоходоо даатгалын суурь хураамжийн хэмжээг доорхи 9 итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцдог.

И₂ итгэлцүүр нь Даатгуулагч даатгалын тохиолдол гаргаж байгаагүй бол дараагийн төлөх даатгалын хураамж нь буурах, эсвэл даатгалын тохиолдол гаргаж нөхөн төлбөр авсан бол хураамж нь нэмэгдэх, хорогдох эсэхийг тодорхойлдог. Даатгалын тохиолдлыг тухайн үед тээврийн хэрэгслийг жолоодож явсан жолоочийн нэр дээр бүртгэнэ. Мөн жолоочийн даатгалын гэрээг анх удаа байгуулж байгаа

болон тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоог хязгаарлахгүй тохиолдолд даатгуулагчийг 3 дугаар бүлэгт оруулж 1 гэсэн утгаар тооцно.

Жишээ нь: Иргэн А 21 настай 1,5 жилийн жолооны туршлагатай. Улаанбаатар хотод амьдардаг. Тэрээр 2500сс мотортой “Toyota mark X” автомашин өмчилдөг. Иргэн А нь 2013 онд Ард даатгалд даатгуулж, уг гэрээний хугацаандаа 2 удаа даатгалын тохиолдол гаргаж, даатгалын компаниасаа 2 хохирогчийнхоо хохирлыг барагдуулж байсан. А нь 2013 оны гэрээний хугацаа нь 2014.11.1-ний өдөр дууссан байна.

Тэгвэл иргэн А нь 2015 онд төлөх жолоочийн даатгалын хураамж нь:

$$X_0 = 33000\text{₮}$$

$$I_1 = 1 \text{ (УБ)}$$

$$I_2 = M \text{ бүлэг} \rightarrow 2.45 \text{ (2 удаа даатгалын тохиолдол гаргасан)}$$

$$I_3 = 1.2 \text{ (21 настай, 1.5 жил туршлагатай)}$$

$$I_4 = 1 \text{ (даатгалын гэрээний хугацаа 1 жил)}$$

$$I_5 = 1 \text{ (мэдээллээ үнэн өгсөн)}$$

$$I_6 = 1 \text{ (жолоочийн тоог хязгаарласан)}$$

$$I_7 = 1 \text{ (В ангиллын тээврийн хэрэгсэл 2001-3000сс)}$$

$$I_8 = 1 \text{ (хувийн)}$$

$$I_9 = 1 \text{ (чиргүүлгүй)}$$

$$X = 33000 \times 1 \times 2.45 \times 1.2 \times 1 \times 1 \times 1 \times 1 \times 1 \times 1 = 97025 \text{ төгрөг}$$

хураамж төлнө гэсэн үг юм.

Тээврийн хэрэгсэл ашиглах жолоочийн тоог хязгаарласан эсвэл хязгаарлаагүйгээс хамаарах нь I_6 итгэлцүүрын утгаас хамаарч даатгалын хураамж нь өөрчлөгдөнө.

Жишээ нь: Иргэн Б нь 26 настай 3 жил жолоо барьсан.

Улаанбаатар хотод амьдардаг ба хувьдаа “Toyota Pri-

us” автомашин өмчилдөг. Б нь 2013 онд анх удаа удаа даатгуулсан бөгөөд тус онд 35640 төгрөг төлж байсан байна. Уг гэрээний хугацаанд Б даатгалын тохиолдолд гаргаагүй болно. Мөн 2013 онд гэрээ байгуулахдаа худал мэдээлэл өгөөгүй, жолоочийн тоог хязгаарлахгүй гэж байгуулсан, автомашины моторын багтаамж нь 1880сс.

Тэгвэл иргэн Б нь 2014 онд төлөх жолоочийн даатгалын хураамж нь:

$$X_0 = 33\,000\text{₮}$$

$$I_1 = 1 \text{ (УБ)}$$

$$I_2 = M \text{ бүлэг} \rightarrow 0.95 \text{ (Даатгалын тохиолдол гаргаагүй учир 4-р бүлэг рүү орж буурч 0,95-аар бодогдоно.)}$$

$$I_3 = 1 \text{ (26 настай, 3 жил туршлагатай)}$$

$$I_4 = 1$$

$$I_5 = 1 \text{ (мэдээллээ үнэн өгсөн)}$$

$$I_6 = 1,5 \text{ (жолоочийн тоог хязгаарлаагүй)}$$

$$I_7 = 0.9 \text{ (В ангиллын тээврийн хэрэгсэл 1001-2000сс)}$$

$$I_8 = 1 \text{ (хувийн)}$$

$$I_9 = 1 \text{ (чиргүүлгүй)}$$

$$X = 33000 \times 1 \times 0.95 \times 1 \times 1 \times 1 \times 1 \times 0.9 \times 1 \times 1 = 28\,215 \text{ төгрөг}$$

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛД ҮЛ ХАМААРАХ ХОХИРОЛ



- Сэтгэл санааны хохирол;
- Хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;
- Даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;
- Энэ хууль болон даатгалын гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

ЖОЛООЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагч дараах үүрэгтэй:



- Жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;
- Даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын баталгааг шалгуулах;
- Даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;
- Даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

Даатгалын тохиолдол гаргасан даатгуулаагүй жолооч дараах үүрэг хүлээнэ:



- Жолоочийн даатгалд даатгуулаагүй тухайгаа хохирогчид мэдэгдэх;
- Даатгалын тохиолдлын талаар шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
- Даатгалын баталгааг тээврийн хэрэгсэлд авч явна.

ХОХИРОГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ



- Даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан бол хохирогч шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
- Хохирогч нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөдөө учирсан хохирлыг нотлох бүх мэдээллийг даатгагч, шуурхай алба, даатгалын хохирол

үнэлэгчид гаргаж өгөх үүрэгтэй.
**ДААТГУУЛАГЧ ТА ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ
 ГАРГАСАН БОЛ ХЭНД ХАНДАХ ВЭ?**

Даатгуулагч та даатгалын тохиолдол гаргасан бол Замын цагдаагийн газрын 124 дугаарын утсанд мэдэгдэж, өөрийн даатгуулсан даатгалын компанийн шуурхай албанд нэн даруй дуудлага өгч мэдэгдэх үүрэгтэйг анхаарна уу! Та дараах хүснэгтээс өөрийн даатгуулсан компаний шуурхай албаны утсыг харах боломжтой.

д/д	ДААТГАЛЫН КОМПАНИ	ШУУРХАЙ АЛБАНЫ УТАС
1	"Мөнх даатгал" ХХК	331332
2	"Номин даатгал" ХХК	330023, 99090679, 70003000
3	"МИГ даатгал" ХХК	330130, 330131, 70003000
4	"Соёмбо даатгал" ХХК	70220707, 77115555
5	"Ард даатгал" ХХК	77200088, 70003000
6	"Монгол даатгал" ХХК	320524, 70170000, 1800-1900
7	"Тэнгэр даатгал" ХХК	312234, 70003000
8	"Бодь даатгал" ХХК	70110280,99054800, 99034800
9	"Монре даатгал" ХХК	70009000, 70003000
10	"Улаанбаатар хотын даатгал" ХХК	70119827, 319826
11	"Практикал даатгал" ХХК	94001525, 99001525, 70003000
12	"Гэр даатгал" ХХК	70139090, 70003000, 94162424
13	"Мандал женерал даатгал" ХХК	70107007, 70117017, 94097007
14	"Ганзам даатгал" ХХК	242667, 242634, 70003000
15	"Хаан даатгал" ХХК	75757588, 99102584, 70003000
16	АвтоСОС	70003000

ДАРААХ ТОХИОЛДОЛД ХААНА ХАНДАХ ВЭ?



- Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан;
- Даатгалын хугацаа нь дууссан;
- Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд Албан журмын даатгагчдын холбооны Шуурхай үйлчилгээний алба /70101177/-нд хандах, хэрвээ та орон нутгаас холбогдож байвалдоорхи салбарын утсанд хандана уу!

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАР

д/д	АЙМАГ	УТАС
1	Архангай	9477-3570
2	Баян-Өлгий	9548-3570
3	Баянхонгор	9472-4070
4	Булган	9453-3570
5	Говь-Алтай	9532-3570
6	Говьсүмбэр	9952-3570
7	Дархан	9471-4050
8	Дорноговь	9471-4070
9	Дорнод	9473-4070
10	Дундговь	9451-3570
11	Завхан	9427-3570
12	Орхон	9472-4050
13	Өвөрхангай	9475-4050
14	Өмнөговь	9473-4050
15	Сүхбаатар	9521-3570

16	Сэлэнгэ	9467-3570
17	Төв	9475-4070
18	Увс	9529-3570
19	Ховд	9479-3570
20	Хөвсгөл	9541-3570
21	Хэнтий	9452-3570

ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ ГАРГАСАН БУРУУТАЙ ЭТГЭЭДИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ



- Өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Жолооны үнэмлэхний хуулбар
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- Оршин суугаа хорооны тодорхойлолт
- Цагдаагийн газрын буруутай этгээдийг тогтоосон акт, тодорхойлолт
- Холбооны мэдээллийн сангийн тодорхойлолт
- Хуучин даатгалын гэрээний эх хувь
- Даатгагч нь дампуурсныг нотолсон эрх бүхий байгууллагын шийдвэр
- Даатгалын гэрээний эх хувь /шинэ/
- Бусад шаардлагатай баримт бичиг

ХОХИРОГЧИЙН БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ



- Хохирогчийн өргөдөл
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Жолооны үнэмлэхний хуулбар
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- Хохирлын хэмжээг тогтоосон дүгнэлт, тодорхойлолт

- Эрх шилжүүлэх гэрээ

Хохирогч /Байгууллага/:

- Албан тоот
- Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Тухайн үед жолоодож явсан этгээдийн өргөдөл
- Жолоочийн үнэмлэхний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар
- Хохирлын хэмжээг тогтоосон дүгнэлт, тодорхойлолт

Хохирогч нас барсан тохиолдолд

- Нас барсны гэрчилгээ
- Хууль ёсны өв залгамжлагчийг нотолсон баримт
- Шаардлагатай тохиолдолд шүүх эмнэлэгийн тодорхойлолт



Эрүүл мэндээрээ хохирсон:

- Хохирогчийн эрүүл мэндэд хохирол учирсаныг нотолсон эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлт
- Холбогдох мэргэжлийн байгууллагын хохирлын хэмжээг тогтоосон дүгнэлт шийдвэр / эм, тариа худалдан авсан баримт, гэх мэт/

Шаардлагатай тохиолдолд:

- Цалингийн тодорхойлолт
- НДД-ийн хуулбар
- Ажилд орсон тушаал
- Бусад

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС ЯМАР ТОХИОЛДОЛД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ВЭ?



- Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан;
- Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан;
- Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус;
- Даатгагч дампуурсан;
- Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

ХОХИРОГЧИД ОЛГОХ НӨХӨН ТӨЛБӨР



- Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамааран даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлыг шалган, хохирлын хэмжээг тодорхойлж нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш ажлын 10 өдрийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.
- Хохирогчийн эд хөрөнгөд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд даатгалын тохиолдлыг шалган, хохирлын хэмжээг тодорхойлж нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш 1 сарын дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.
- Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа хохирогчтой тохиролцсоны дагуу даатгалын үнэлгээнд багтаан эд хөрөнгийг

засуулахаар тохиролцож болно.

- Хохирогчид олгох нөхөн төлбөрийн 80 хүртэл хувийг хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохиролд, 20 хүртэл хувийг хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохиролд олгоно.

НӨХӨН ТӨЛБӨР БУЦААН НЭХЭМЖЛЭХ ҮНДЭСЛЭЛ

1) Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

- Хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;
- Даатгалын тохиолдол гарсан талаар мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;
- Даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;
- Даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;
- Хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.



2) Жолоочийн даатгалын сан нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай



этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

- Хохирогчид хохирол учирсан нь жолоочийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;
- Даатгалгүй жолоочийн гэм буруугаас шалтгаалан хохирогчид хохирол учирсан гэдэг нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн жолоочоос;
- Даатгалын тохиолдол гаргаад зугтаасан жолоочийн учруулсан хохирлын хувьд тухайн жолоочоос;
- Даатгагч нь дампуурсан бол хуулийн дагуу эрх залгамжлан авсан этгээдээс;
- Хуульд заасан бусад үндэслэл.

ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧСӨН ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГААС

Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч уг буруутай этгээдэд дараах захиргааны хариуцлага ногдуулна:

- Жолоочийн даатгалд даатгуулаагүй эдгээд болон даатгалын баталгааг автотээврийн хэрэгсэлд байнга байршуулж эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд шалгуулаагүй этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, жолоочийн даатгалд даатгуулах хүртэл тээврийн хэрэгслийг тусгай хашаа /талбай/-д байлгаж, зардлыг

буруутай этгээдээр төлүүлэх;

- Даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн шаардсан хугацаанд гаргаж өгөөгүй даатгуулагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

ДААТГУУЛАГЧИЙН АНХААРАХ ЗҮЙЛС

- Мэдээллийн санд даатгалын гэрээ нь бүртгэгдсэн эсэх талаар **smartcar.mn** сайт болон автодорцов гар утасны аппликейшн ашиглаж мэдээлэл хайх, шалгах боломжтой;
- Даатгуулагч даатгалын гэрээ байгуулахдаа өөрийн нөхөн төлбөр авсан эсэх, даатгагчийн хаяг, утасны дугаар зэргийг сайтар шалгах,
- Мэдээллийн санд орсон мэдээлэл алдаатай, мөн таны гэрээ мэдээллийн санд ороогүй байвал өөрийн Даатгалын компанид хандах, шаардлагатай тохиолдолд Албан журмын даатгагчдын холбооны Мэдээллийн сан **7012-1177** утасны дугаарт хандаж шалгуулах.

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
6-р хороо, 6-р хороолол, Их тойруу 68/1
Логос төв, 7-р давхар

Утас: 70101177, 70001277, 70121177

Веб сайт: www.ami.mn

Фейсбүүк: www.facebook.com/www.AMI.mn